



**МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2008 оны 11 сарын 28 өдөр

Дугаар 242

Улаанбаатар хот

“Даатгагчийн дүрмийн сан болон нөөц сангаас хөрөнгө оруулалт хийхэд тавигдах шаардлага”-ыг шинэчлэн батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Даатгалын тухай хуулийн 14.1, 14.2.3, 14.2.4, 25.2, 25.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.“Даатгагчийн дүрмийн сан болон нөөц сангаас хөрөнгө оруулалт хийхэд тавигдах шаардлага”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Дүрмийн сан болон нөөц сангийн мөнгөн хөрөнгийг энэхүү тогтоолын дагуу байршуулж Хороонд 2008 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор биелэлтийг мэдэгдэхийг даатгалын компаниудад үүрэг болгосугай.

3.Хорооны 2006 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагчийн дүрмийн сан болон нөөц сангаас хөрөнгө оруулалт хийхэд тавигдах шаардлага”-ыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/-т, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН

ДААТГАГЧИЙН ДҮРМИЙН САН БОЛОН НӨӨЦ САНГААС ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Даатгалын тухай хуулийн 14.2.4, 25.2, 25.3 дахь хэсэгт заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-ноос ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон хуулийн этгээд (цаашид “Даатгагч” гэх)-ийн дүрмийн сан болон даатгалын нөөц сангийн мөнгөн хөрөнгийг хөрөнгө оруулалтад зохистой харьцаатайгаар оновчтой байршуулахад оршино.

1.2. Даатгагчийн дүрмийн сан болон даатгалын нөөц сангаас хийх хөрөнгө оруулалтын зорилго нь даатгалын зах зээлийн тогтвортой хөгжлийг хангах, даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах, нөөц сангаас даатгуулагч нарт даатгалын гэрээний дагуу олгох нөхөн төлбөрийн шаардлагыг хангахад даатгагчийн мөнгөн хөрөнгийг хангалттай хүрэлцэхүйц, баталгаатай, найдвартай байлгахад оршино.

1.3. “Нэгдмэл сонирхолтой этгээд” гэж Компанийн тухай хуулийн 97.1-д зааснаар ойлгоно.

ХОЁР. Хөрөнгө оруулалтад тавигдах шаардлага

2.1. Даатгагчийн дүрмийн сан болон нөөц сангаас хөрөнгө оруулалт хийхэд дараах шаардлага тавигдана:

2.1.1. Даатгагч нь Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх хувь нийлүүлэгчид, үүсгэн байгуулагчид)-өөр баталгаажуулсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөтэй байх ба уг төлөвлөгөөнд энэ журмын 3.1-д заасан зүйлийг тусгасан байна;

2.1.2. Даатгагч нь хөрөнгө оруулалтын төлөвлөгөөгөө жил бүр Хороонд ирүүлж байна;

2.1.3. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг энэ журмын 4.1, 4.3, 5.1 болон 5.4-т заасан хязгаарлалтын хүрээнд боловсруулсан байна;

2.1.4. Хорооны 2006 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгалын нөөцийн сан бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ын 2.1.3-д заасан “Учирч болзошгүй хохирлын нөөц” сангаас энэ журамд заасны дагуу хөрөнгө оруулалт хийж болно;

2.1.5. “Даатгалын нөөцийн сан бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ын 2.1.1-д заасан “Орлогд тооцоогүй хураамжийн нөөц”, “Нэхэмжилсэн хохирлын нөөц” сангуудын хөрөнгөнөөс банкны хадгаламж болон харилцах дансанд байршуулахаас өөр хэлбэрээр хөрөнгө оруулалт хийхийг хориглоно;

2.1.6. Даатгагч нь хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг Монгол Улсын хилийн чанадад эрхлэх тохиолдолд гагцхүү Хорооны зөвшөөрлийн үндсэн дээр гүйцэтгэж болно;

2.1.7.Хэрэв даатгагч нь гадаадын улс оронд байрлах хөрөнгөд хөрөнгө оруулалт хийхийг хүсвэл Хороонд бичгээр хүсэлт тавьж, зөвшөөрөл авна;

2.1.8.Даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан “холбогдох этгээд”-д дараах нөхцөлийн аль нэгийг хангаж буй иргэн, хуулийн этгээдийг хамааруулах бөгөөд даатгагчаас түүнд аливаа сангаас зээл олгохыг хориглоно:

2.1.8.1.Даатгалын компанийн толгой болон зэрэгцээ компаниуд;

2.1.8.2.Даатгалын компанийн хувь нийлүүлэгч, ТУЗ-ийн дарга, гишүүн, гүйцэтгэх захирал, даатгалын салбарын захирал, тэдгээрийн өвөг эцэг, эмэг эх, эцэг, эх, эхнэр, нөхөр, ах, эгч, дүү, хүүхэд болон тэдэнд хяналтын багцаа эзэмшүүлдэг хуулийн этгээд, уг хуулийн этгээдийн хяналтын багцыг эзэмшдэг аливаа иргэн, хуулийн этгээд;

2.1.8.3.Барьцаа хөрөнгөгүй эсвэл барьцаа хөрөнгө нь хангалтгүй буюу барьцаа хөрөнгийн зах зээлийн үнэлгээ нь зээлийн үндсэн өр болон хүүгийн төлбөрийг барагдуулахад хүрэхгүй байгаа иргэн, хуулийн этгээд;

2.1.8.4.Иргэн, эсхүл компанийн удирдлагатай холбоотой хэрэг, маргаан үүссэний улмаас эрх бүхий байгууллагаар хянагдаж, шалгагдаж байгаа этгээд;

2.1.8.5.Тухайн даатгалын компанийн даатгуулагч;

2.1.8.6.Даатгалын компанийн холбогдох этгээд гэж үзсэн бусад этгээд.

ГУРАВ. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө

3.1.Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд дараах зүйлийг тусгана:

3.1.1.Энэ журмын 4.1 болон 5.1-т заасан хязгаарлалт дээр үндэслэсэн тухайн компанийн хөрөнгө хуваарилалтын байдал;

3.1.2.Энэ журмын 4.1 болон 5.3-т заасан хөрөнгө оруулалтын хувь хэмжээ;

3.1.3.Өөрийн компанийн даатгалын болон давхар даатгалын үйл ажиллагааны байдлыг тусгасан даатгалын компанийн эрсдэлийн менежментийн төлөвлөгөө;

3.1.4.Төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийн зохистой харьцаа;

3.1.5.Даатгуулагчдын өмнө хүлээсэн хариуцлага болон хөрөнгө оруулалтад байршуулсан хөрөнгийн эргэн төлөгдөх хугацаа;

3.1.6.Даатгагчийн үйл ажиллагаатай холбоотой үүсч болзошгүй бусад эрсдэлийг удирдах талаар;

3.1.7.Даатгалын тохиолдол үүсэхэд учирсан хохирол буюу хэлэлцэн тохирсон даатгалын нөхөн төлбөрийг төлөх үүргээ бүрэн хэрэгжүүлэх зорилгоор даатгагч нь хөрөнгө оруулалтад байршуулсан хөрөнгийг шуурхай татан төвлөрүүлж, хохирлыг барагдуулах талаар.

3.2.Даатгагчийн гүйцэтгэх удирдлага нь хөрөнгө оруулалтыг ТУЗ-аас баталсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу гүйцэтгэнэ.

3.3.ТУЗ нь холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлт, эрсдэлийн удирдлага, мэдээлэл, дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл болон хөндлөнгийн аудитын үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж ажиллана.

ДӨРӨВ. Дүрмийн сангийн хөрөнгө оруулалт, байршил

4.1.Даатгалын тухай хуулийн 22.1-д заасан даатгагчийн дүрмийн сангийн хөрөнгийн 100 хувийг дараах хэмжээгээр хөрөнгө оруулалтад байршуулж болно:

4.1.1.Банкны хадгаламж:100 хүртэл хувь. Энэ журмын 4.1-д заасан дүрмийн сангийн хөрөнгийг банкны хадгаламжид байршуулахдаа нэг банкинд 30 хувиас хэтрэхгүйгээр хадгалуулна. Хэрэв даатгагчийн аль нэг хувь нийлүүлэгч нь тухайн арилжааны банктай болон банкны хувь нийлүүлэгчтэй энэ журмын 1.3-т заасан нэгдмэл сонирхолтой этгээдийн харилцаатай болон даатгагчийн толгой, зэрэгцээ компани, нэг санхүүгийн нэгдэлд байдаг арилжааны банкинд хөрөнгөө хадгалуулахаар бол дүрмийн сангийн нийт хөрөнгөнөөс 10 хувиас хэтрэхгүйгээр хадгалуулна;

4.1.2.Банкны харилцах дансанд байршуулах: 100 хүртэл хувь байх бөгөөд энэ журмын 4.1-д заасан дүрмийн сангийн хөрөнгийг банкинд дахь харилцах дансанд байршуулахдаа арилжааны нэг банкинд 30 хувиас хэтрэхгүйгээр байршуулна. Хэрэв даатгагчийн аль нэг хувь нийлүүлэгч нь тухайн арилжааны банктай болон банкны хувь нийлүүлэгчтэй энэ журмын 1.3-т заасан нэгдмэл сонирхолтой этгээдийн харилцаатай, даатгагчийн толгой, зэрэгцээ компани, нэг санхүүгийн нэгдэлд байдаг арилжааны банкинд хөрөнгөө байршуулахаар бол дүрмийн сангийн нийт хөрөнгийн 10 хувиас хэтрэхгүйгээр байршуулна */Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 20 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан/;*

4.1.3.Засгийн газрын өрийн бичиг: 100 хүртэл хувь;

4.1.4.Төв банкны үнэт цаас: 60 хүртэл хувь;

4.1.5.Орон нутгийн засаг захиргааны бонд: 20 хүртэл хувь;

4.1.6.Үл хөдлөх хөрөнгөөр барьцаалсан үнэт цаас: 20 хүртэл хувь;

4.1.7.Банкны хадгаламжийн сертификат: 10 хүртэл хувь;

4.1.8.Компанийн бонд: 10 хүртэл хувь;

4.1.9.Санхүүгийн болон үйл ажиллагааны лизинг: 5 хүртэл хувь;

4.1.10.Энэ журмын 2.1.8-д заасан “холбогдох этгээд”-ээс бусад этгээдэд Даатгалын тухай хуулийн 27.1.3-т заасны дагуу үл хөдлөх хөрөнгө барьцаалсан арилжааны богино хугацаат (нэг жил хүртэл) зээл 5 хүртэл хувь;

4.1.11.Үл хөдлөх хөрөнгө: 20 хүртэл хувь.

4.2.Энэ журмын 4.1.1 болон 4.1.7-д заасан хөрөнгө оруулалтын нийлбэр дүн 30 хувиас хэтрэхгүй байна.

4.3.Дүрмийн сангийн хөрөнгөөс урт болон богино хугацаат хөрөнгө оруулалт хийж болно.

ТАВ. Нөөц сангийн хөрөнгө оруулалт, байршил

5.1.Даатгагч нь учирч болзошгүй хохирлын нөөц сангийн 30 хувийг компанийн тусгайлсан дансанд байршуулна. Энэ сангийн үлдэх 70 хувийг энэхүү журмын 5.3-т заасны дагуу хөрөнгө оруулалтад байршуулж болно. */Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 20 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/*

5.2.Нөөц сангаас зөвхөн богино хугацаат (нэг жил хүртэл) хөрөнгө оруулалт хийж болно.

5.3.Энэ журмын 5.1-д заасан учирч болзошгүй хохирлын нөөц сангийн 70 хувийг дараах хэмжээгээр хөрөнгө оруулалтад байршуулж болно */Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 20 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/:*

5.3.1.Банкны хадгаламж: 100 хүртэл хувь. Энэ журмын 5.1-д заасан нөөц санг банкны хадгаламжид байршуулахдаа нэг банкинд 20 хувиас хэтрэхгүйгээр хадгалуулна. Хэрэв даатгагчийн аль нэг хувь нийлүүлэгч нь тухайн арилжааны банктай болон банкны хувь нийлүүлэгчтэй энэ журмын 1.3-т заасан нэгдмэл сонирхолтой этгээдийн харилцаатай болон даатгагчийн толгой, зэрэгцээ компани, нэг санхүүгийн нэгдэлд байдаг арилжааны банкинд хөрөнгөө хадгалуулахаар бол нөөц сангийн хөрөнгөнөөс 10 хувиас хэтрэхгүйгээр хадгалуулна;

5.3.2.Банкны харилцах дансанд байршуулах: 100 хүртэл хувь байх бөгөөд энэ журмын 5.1-д заасан нөөц сангийн хөрөнгийг арилжааны банкин дахь харилцах дансанд байршуулахдаа нэг банкинд 20 хувиас хэтрэхгүйгээр байршуулна. Хэрэв даатгагчийн аль нэг хувь нийлүүлэгч нь тухайн арилжааны банктай болон банкны хувь нийлүүлэгчтэй энэ журмын 1.3-т заасан нэгдмэл сонирхолтой этгээдийн харилцаатай болон даатгагчийн толгой, зэрэгцээ компани, нэг санхүүгийн нэгдэлд байдаг арилжааны банкинд хөрөнгөө байршуулахаар бол нөөц сангийн хөрөнгийн 10 хувиас хэтрэхгүйгээр байршуулна */Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 20 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан/;*

5.3.3.Засгийн газрын өрийн бичиг: 100 хүртэл хувь;

5.3.4.Төв банкны үнэт цаас: 60 хүртэл хувь;

5.3.5.Орон нутгийн засаг захиргааны бонд: 20 хүртэл хувь;

5.3.6.Үл хөдлөх хөрөнгөөр барьцаалсан үнэт цаас 20 хүртэл хувь;

5.3.7.Банкны хадгаламжийн сертификат: 10 хүртэл хувь;

5.3.8.Компанийн бонд: 10 хүртэл хувь;

5.3.9.Санхүүгийн болон үйл ажиллагааны лизинг: 5 хүртэл хувь;

5.3.10.Энэ журмын 2.1.8-д заасан “холбогдох этгээд”-ээс бусад этгээдэд Даатгалын тухай хуулийн 27.1.3-т заасны дагуу үл хөдлөх хөрөнгө барьцаалсан арилжааны богино хугацаат (нэг жил хүртэл) зээл 5 хүртэл хувь.

5.4.Энэ журмын 5.3.1 болон 5.3.7-д заасан хөрөнгө оруулалтыг нэг банкинд хийхээр бол нийлбэр дүн нь 20 хувиас хэтрэхгүй байна.

~~5.5.Энэ журмын 4.1.1 болон 5.3.1 д заасан дүрмийн сан болон нооц сангийн харилцах дансны мөнгөн хөрөнгийн нийлбэр дүн нь нэг банкинд 30 хувиас, хэрэв даатгагчийн хувь нийлүүлэгч тухайн арилжааны банктэй болон банкны хувь нийлүүлэгчтэй энэ журмын 1.3-т заасан нэгдмэл сонирхолтой этгээдийн харилцаатай болон даатгагчийн төлгөй, зэрэгцээ компани, нэг санхүүгийн нэгдэлд байдаг арилжааны банкинд хөрөнгөө хадгалуулахаар бол дүрмийн сан болон нооц сан, харилцах дансны мөнгөн хөрөнгийн нийлбэр дүн нь 15 хувиас тус тус хэтрэхгүй байна. /Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 20 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/~~

5.6.Даатгагчийн каст байх мөнгөн (төгрөг, валют) хөрөнгийн дээд хязгаар нь нийт мөнгөн хөрөнгийн 10 хувиас хэтрэхгүй байна.

5.7.Даатгагч нь энэ журамд зааснаар мөнгөн хөрөнгийг хөрөнгө оруулалт болон бусад хэлбэрээр байршуулахдаа өмнөх улирлын эцсийн үлдэгдлээс тогтоосон хувиар тооцож байршуулна.

ЗУРГАА. Энэ журмыг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

6.1.Хөрөнгө оруулалтад тавигдах шаардлагыг биелүүлээгүй болон заавал байршуулах нөөцийг дутагдуулсан даатгагчийн албан тушаалтныг Даатгалын тухай хуулийн 83.1.32-т заасны дагуу 50 000-100 000 төгрөгөөр, даатгагчийг 500 000-1 000 000 төгрөгөөр торгоно.

6.2.Заавал байршуулах нөөцийн доод хэмжээг 3 сараас дээш хугацаагаар үргэлжлүүлэн хангаагүй буюу хөрөнгө оруулалтад тавигдах шаардлагыг удаа дараа биелүүлээгүй зөрчсөн даатгагчид ногдуулах албадлагын арга хэмжээний тухай саналыг Хорооны хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

ДОЛОО. Хөрөнгө оруулалт болон заавал байршуулах нөөцөд тавих хяналт

7.1.Даатгагчийн хөрөнгө оруулалтын болон заавал байршуулах нөөцийн үйл ажиллагаанд Хороо хяналт тавина.

7.2.Даатгагч нь хөрөнгө оруулалтын болон заавал байршуулах нөөцийн тайланг Хорооноос баталсан маягтын дагуу гаргаж, Хороонд улирал тутам ирүүлнэ.

--ooOoo--